БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/94/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: У.Ербол<br>Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

**АГУУЛГА**


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .... 4

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .... 6

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** .... 15

**4. АУДИТЫН ТАЙЛАН** .... 19

**4.1 Ерөнхий зүйл** .... 19

**4.2 Материаллаг байдал** .... 19

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** .... 19

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 19

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** .... 19

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** .... 20

**4.5.1 Завсрын аудитын талаар** .... 20

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** .... 20

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .... 20

**5.1 Төлбөрийн акт** .... 21

**5.2 Албан шаардлага** .... 21

**5.3 Зөвлөмж** .... 21

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .... 21

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.24 № 224
танай ______ -ны № ______ -т

УЛААНХУС СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.БОТАКӨЗ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **22,801,754.00** | **23,563,000.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 45,210.00 | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 45,210.00 | - |
| **3121** | **Төгрөг** | 45,210.00 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 45,210.00 | - |
| **33** | **АВЛАГА** | 1,804,544.00 | 1,500,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,804,544.00 | 1,500,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 20,952,000.00 | 22,063,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 11,052,000.00 | 12,163,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,052,000.00 | 12,163,000.00 |
| 35600 | Мал амьтад | 9,900,000.00 | 9,900,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,429,630,215.61** | **9,191,254,513.16** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,429,630,215.61 | 9,191,254,513.16 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,426,306,215.61 | 8,963,950,513.16 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,266,445,365.30 | 2,962,630,642.51 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (573,031,568.69) | (327,980,581.66) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 225,001,434.00 | 225,001,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (132,988,702.64) | (153,231,044.96) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 54,944,915.00 | 54,777,915.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (36,234,498.23) | (37,468,331.58) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,375,721.00 | 7,955,671.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,590,992.93) | (3,072,604.05) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,658,510,375.00 | 5,852,808,544.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (50,570,276.64) | (89,836,408.86) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,000,000.00 | 136,700,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,555,555.56) | (7,334,722.24) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | - | 343,000,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,324,000.00 | 227,304,000.00 |
| 39301 | Програм хангамж | 536,400.00 | 10,336,400.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (536,400.00) | (536,400.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,324,000.00 | 217,504,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,452,431,969.61** | **9,214,817,513.16** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,295,234.00** | **10,381,364.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 6,295,234.00 | 10,381,364.00 |
| **413** | **Өглөг** | 6,295,234.00 | 10,381,364.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 5,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **4136** | **Бусад өглөг** | 6,295,234.00 | 5,381,364.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 6,295,234.00 | 5,381,364.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,446,136,735.61** | **9,204,436,149.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,446,136,735.61 | 9,204,436,149.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,795,227,276.32 | 2,009,407,276.32 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,795,227,276.32 | 2,009,407,276.32 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,322,361,915.44 | 5,936,852,637.03 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,322,361,915.44 | 1,392,733,223.48 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 4,544,119,413.55 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,328,547,543.85 | 1,258,176,235.81 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,452,431,969.61** | **9,214,817,513.16** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **663,556,730.00** | **5,314,278,269.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **663,556,730.00** | **5,314,278,269.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 4,573,831,969.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | 36,533,800.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | 4,537,298,169.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 90,750,975.00 | 6,258,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,607,175.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 89,143,800.00 | 640,000 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 5,618,600 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 572,805,755.00 | 734,187,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 483,592,210.00 | 510,609,700.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 89,213,545.00 | 223,578,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **695,746,689.53** | **686,534,701.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **695,746,689.53** | **686,534,701.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 671,835,289.53 | 611,888,891.85 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 309,139,594.50 | 317,733,944.00 |
| 210101 | Үндсэн цалин | 307,639,594.50 | 317,733,944.00 |
| 210104 | Урамшуулал | 1,500,000.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40,173,960.50 | 38,588,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,836,541.84 | 26,701,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,075,200.00 | 3,388,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,460,100.00 | 2,266,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 343,918.66 | 566,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,458,200.00 | 5,665,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,702,634.00 | 24,554,040.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,378,400.00 | 1,785,825.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22,324,234.00 | 22,768,215.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,814,757.00 | 36,413,450.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,833,250.00 | 4,811,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,321,007.00 | 27,033,750.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,572,800.00 | 4,568,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 87,700.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 417,100.00 | 314,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 417,100.00 | 314,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 878,000.00 | 6,628,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 878,000.00 | 6,628,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 555,500.00 | 5,842,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 555,500.00 | 1,842,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,711,718.00 | 1,381,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 877,300.00 | 262,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 302,200.00 | 362,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,300.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 185,700.00 | 185,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 144,000.00 | 333,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37,218.00 | 37,300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 35,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 260,442,025.53 | 180,433,057.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 125,680,602.00 | 22,816,240.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 70,000.00 | 576,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 134,691,423.53 | 157,040,717.85 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,911,400.00 | 74,645,810.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 36,533,800.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 36,533,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,911,400.00 | 38,066,600.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 23,911,400.00 | 14,038,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 24,028,300.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 45,410.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 45,410.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(32,189,959.53)** | **4,627,743,567.15** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | (5,060,050.93) | (83,624,153.60) |
| 145003 | Хөрөнгө оруулалтын олз | (5,060,050.93) | (83,624,153.60) |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (5,060,050.93) | (83,624,153.60) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(37,250,010.46)** | **4,544,119,413.55** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **574,343,185.00** | **553,402,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **574,343,185.00** | **553,402,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 36,533,800.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | 36,533,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 90,750,975.00 | 6,258,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,607,175.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 89,143,800.00 | 640,000 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 5,618,600 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 483,592,210.00 | 510,609,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 483,592,210.00 | 510,609,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **567,250,504.00** | **526,214,310.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **567,250,504.00** | **526,214,310.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **543,339,104.00** | **451,568,500.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 311,738,709.00 | 312,429,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 227,095,175.00 | 235,082,330.00 |
| 210102 | Нэмэгдэл | 64,855,608.00 | 55,587,070.00 |
| 210104 | Урамшуулал | 1,500,000.00 | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 18,287,926.00 | 21,760,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,304,300.00 | 38,588,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,003,500.00 | 26,701,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,075,200.00 | 3,388,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,460,100.00 | 2,266,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 615,100.00 | 566,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,150,400.00 | 5,665,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,469,400.00 | 27,926,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,440,400.00 | 865,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,029,000.00 | 27,061,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,986,600.00 | 31,617,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,322,000.00 | 3,158,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,003,800.00 | 23,860,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,572,800.00 | 4,568,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88,000.00 | 29,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 457,000.00 | 457,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000.00 | 457,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,989,400.00 | 7,594,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,989,400.00 | 7,594,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 555,500.00 | 5,842,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 555,500.00 | 1,842,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,341,300.00 | 1,369,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,915,200.00 | 249,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 302,200.00 | 362,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,300.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 185,700.00 | 185,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 398,700.00 | 333,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 289,200.00 | 37,300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 85,000.00 | 35,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 135,496,895.00 | 25,744,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 134,996,895.00 | 24,827,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 917,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23,911,400.00** | **74,645,810.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 36,533,800.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | 36,533,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,911,400.00 | 38,066,600.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 23,911,400.00 | 14,038,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 24,028,300.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 45,410.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 45,410.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,092,681.00** | **27,187,790.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,747,780.00** | **27,233,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,747,780.00** | **27,233,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,747,780.00 | 27,233,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,747,780.00 | 27,233,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(8,747,780.00)** | **(27,233,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (1,655,099.00) | (45,210.00) |

| | | | |
|---|---|---|---|
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 1,700,309.00 | 45,210.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 45,210.00 | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,795,227,276.32 | 1,328,547,543.85 | 1,322,361,915.44 | | 4,446,136,735.61 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,795,227,276.32** | **1,328,547,543.85** | **1,322,361,915.44** | **0.00** | 4,446,136,735.61 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,795,227,276.32** | **1,328,547,543.85** | **1,322,361,915.44** | **0.00** | 4,446,136,735.61 |
| D01 | **2021оны 12-р сарын3 1-нээрх үлдэгдэл** | **1,795,227,276.32** | **1,328,547,543.85** | **1,322,361,915.44** | **0.00** | 4,446,136,735.61 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 70,371,308.04 | | 70,371,308.04 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,795,227,276.32** | **1,328,547,543.85** | **1,392,733,223.48** | **0.00** | 4,516,508,043.65 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -70,371,308.04 | | | -70,371,308.04 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 214,180,000.00 | | | | 214,180,000.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 4,544,119,413.55 | | 4,544,119,413.55 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,009,407,276.32** | **1,258,176,235.81** | **5,936,852,637.03** | **0.00** | 9,204,436,149.16 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 45,210.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 547,143,500.00 | 547,143,300.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 547,143,500.00 | 547,143,300.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 472,543,100.00 | 472,542,900.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 312,429,400.00 | 312,429,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 237,124,300.00 | 235,082,330.00 |
| 210102 | Нэмэгдэл | 53,545,100.00 | 55,587,070.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,760,000.00 | 21,760,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,588,500.00 | 38,588,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,701,800.00 | 26,701,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,388,300.00 | 3,388,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,266,300.00 | 2,266,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 566,500.00 | 566,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,665,600.00 | 5,665,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,926,700.00 | 27,926,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 865,000.00 | 865,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,061,700.00 | 27,061,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,617,300.00 | 31,617,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,158,500.00 | 3,158,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,860,900.00 | 23,860,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,568,700.00 | 4,568,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 29,200.00 | 29,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 457,000.00 | 457,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000.00 | 457,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 27,594,500.00 | 27,594,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 27,594,500.00 | 27,594,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,192,000.00 | 5,192,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 1,192,000.00 | 1,192,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,369,000.00 | 1,369,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 249,900.00 | 249,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 362,200.00 | 362,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,300.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 185,700.00 | 185,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 333,600.00 | 333,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37,300.00 | 37,300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 35,000.00 | 35,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27,368,700.00 | 27,368,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,993,700.00 | 19,993,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,375,000.00 | 7,375,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 74,600,400.00 | 74,600,400.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 36,533,800.00 | 36,533,800.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 36,533,800.00 | 36,533,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 38,066,600.00 | 38,066,600.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 14,038,300.00 | 14,038,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,028,300.00 | 24,028,300.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 547,143,500.00 | 547,098,090.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 36,533,800.00 | 36,533,800.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 36,533,800.00 | 36,533,800.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 510,609,700.00 | 510,564,290.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 510,609,700.00 | 510,564,290.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 45,210.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 31 | 34 |
| 620001 | Удирдах ажилтан | 14 | 14 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 |
| 620004 | Гэрээт ажилтан | 5 | 8 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **31** | **34** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 9 | 12 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 13 | 13 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,258,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,258,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,258,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 650,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 650,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,608,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,608,600.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **6,258,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **6,258,600.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,071,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,187,400.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын зорилго нь нутгийн залуу боловсон хүчнийг ажлын байраар хангах, мэргэшүүлж чадварлаг боловсон хүчин бий болгох, өндөр мэдлэг, ур чадвартай мэргэшсэн албан хаагчдыг үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, хуулиар тусгаарлан олгосон чиг үүргийн дагуу нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн ам, нийгэм эдийн засгийн төлөвлөлтийг бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулахын зэрэгцээ төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, шударга байдал, ур чадварыг дээшлүүлэн төрийн бүх үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргахад оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Алсын хараа, хэтийн зорилгын хүрээнд орон нутгаа хөгжүүлэх,
- Шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөлт хийж, орон нутгийн нөөц, иргэдийн санаачилгад тулгуурлан хөгжүүлэх,
- Орон нутгийн иргэдийн сумаа хөгжүүлэх гэсэн хүсэл эрмэлзэл, төрийн албан хаагчдын үйлчилгээгээ нээлттэй ил тод, хөнгөн шуурхай хүргэх,
- Ая тухтай хүний аюулгүй байдлыг цогцлон бүрдүүлэх

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүрэг нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болон хэтийн төлөвлөгөөний биелэлтийг хянах, байгууллага, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг тасралтгүй хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллахад оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны А/02 тоот тушаалаар баталсан ”Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн батлах тухай журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,762.4 сая төгрөгөөр буюу 2 дахин нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 45,2 | | -45,2 |
| Авлага | 1,804,5 | 1,500,0 | -304.5 |
| Бараа материал | 20,952,0 | 22,063,0 | 1,111.0 |
| Үндсэн хөрөнгө | 4,429,630,2 | 9,191,254,5 | 4,761,624.3 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **4,452,431,9** | **9,214,817,5** | **4,762,385.6** |
| Өр төлбөр | 6,295,2 | 10,381,4 | 4,086.2 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 4,446,136,7 | 9,204,436,1 | 4,758,299.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **4,452,431,9** | **9,214,817,5** | **4,762,385.6** |

Авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс жилийн эцэст үлдэгдэлгүй ба авлагын данс 0.3 сая төгрөгөөр буурч, бараа материалын данс 1.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс 4,761.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сумын төвд шинээр барьж байгуулсан засмал зам 4,194.3 сая , аймгийн ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтээр Хөх хөтөл багт баригдаж буй бетон гүүр 343.0 сая, сумын ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтээр барьж байгуулсан 223.5 сая төгрөгийн хөрөнгө болон аймгийн Орон нутгийн өмчийн газрын улсын тооллогоор бүртгүүлсэн 214.8 сая төгрөгийн үнэлгээтэй газраар нэмэгдэж, аймгийн ИТХ-ын 2022 оны 104 дугаар тогтоолоор акталсан 423.7 сая төгрөгийн хөрөнгө болон элэгдлийн зардлаар буурсантай холбоотой байна.

Жилийн эцэст 10.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй гарсан нь түлш халаалтын 2.0 сая, цахилгааны зардлын 0.9 сая, тээвэр шатахууны 1.1 сая, бичиг хэргийн 1.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн 5.0 сая төгрөгийн өр байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 4,758.2 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 647.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 24.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 35.0 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 23.5 сая төгрөгөөр, нормативт зардал 0.9 сая төгрөгөөр, албан томилолт, зочны зардал 8.1 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 3.6 сая төгрөгөөр бууруулж, эд хогшил, урсгал засварын зардлыг 15.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 20.6 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 26.9 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант оны батлагдсан төсвийг 103.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 510.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 36.5 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 510.6 сая төгрөг, улсын төсвөөс 36.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 0.04 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 547.1 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 320,915.2 | 320,915.2 | | 100% |
| 2 | Туслах үйл ажиллагааны зардал | 138,627.9 | 138,627.7 | 0.2 | 100% |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 14,038.3 | 14,038.3 | | 100% |
| 4 | Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг | 24,028.3 | 24,028.3 | | 100% |
| | Улсын их баяр наадам | 3,000.0 | 3,000.0 | | 100% |
| | Нөөц хөрөнгө | 10,000.0 | 10,000.0 | | 100% |
| 5 | ОНХС - Итгэлцүүрээр олгох | 36,533.8 | 36,533.8 | | 100% |
| | **Дүн** | **547,143.5** | **547,143.3** | | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Статистикийн хэлтсээс 3.7 сая, бусад орлогоос 2.5 сая төгрөгийн орлого оруулж, албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардлуудад зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 3/37 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 695.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад бараа, үйлчилгээний бусад зардлаас Буянт, Ногооннуур сумдад 0.3 сая төгрөгийн хандив өгч, зочин хүлээн авах зардлаас 0.1 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан зөрчил гаргасан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 547.1 сая төгрөгийн 26 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 273.2 сая төгрөгийн 16 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж шилэн дансны хэрэгжилт 100 %-тай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 70.4 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 70.4 сая төгрөгийн алдааг залруулав.Үүнд:

Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн барилга байгууламжийн дансны хасалтад тусгасан 325.8 сая төгрөгөөс хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 70.4 сая төгрөгийг салгаж залруулав.

Аудитаар нийт 8.7 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 8.3 сая төгрөгийн зөрчилд нэг албан шаардлага хүргүүлсэн болно.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчилд төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1. Зочин хүлээн авах зардлаас 0.1 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөв.Үүнд:

1.Сумын удирдлагууд аймагт албаны ажлаар ажиллахад 5.5 сая төгрөгийн шатахууныг баталсан удирдамжгүй, албан томилолтгүй, дотоод хяналтгүй зарцуулсан, шүлхий өвчний гарсан үед бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан 1.5 сая төгрөгийн шатахуун, 1.3 сая төгрөгийн урсгал засвар нийт 8.3 сая төгрөгийг бүрдэл дутуу баримтаар зарцуулсан зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн барилга байгууламжийн дансны хасалт | 1 | 70,371.3 | | | 1 | 70,371.3 | 1 | 70,371.3 | | | | |
| **Дүн** | **1** | **70,371.3** | | | **1** | **70,371.3** | **1** | **70,371.3** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бүрдэл дутуу баримтаар гүйлгээ гаргасан | 1 | 8,265.5 | | | 1 | 8,265.5 | | | | | | |
| **Дүн** | **1** | **8,265.5** | | | **1** | **8,265.5** | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авсан | 1 | 116.0 | 1 | 116.0 | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 116.0 | 1 | 116.0 | | | | |
| **Нийт дүн** | 1 | 416.0 | 1 | 416.0 | | | | |